



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

2019-2020 ОНЫ БАГШ
НАРЫН ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ
ИЛТГЭЛИЙН ЭМХТГЭЛ

2020 ОН

Говьсүмбэр аймаг дахь Уул уурхайн жишиг сургууль
Политехник коллеж

ИЛТГЭЛ

Илтгэлийн сэдэв: Төрийн албан хаагчдын EQ чадварыг онлайн сургалт ашиглан сайжруулах нь

Илтгэгч: Гидравликийн багш. Боловсрол судлалын магистр /Б.Мэндбаяр/
ЭЗО-ын багш. Бизнесийн удирдлагын магистр /М.Баярмаа/

Говьсүмбэр аймаг
2019 он

Агуулга

- Түлхүүр үг
- Судалгааны үндэслэл
- Судалгааны ажлын зорилго
- Судалгааны зорилтууд
- Судалгааны арга зүй

НЭГ ДҮГЭЭР БҮЛЭГ: ОНОЛЫН АРГА ЗҮЙ

- 1.1 Хүний оюун ухааныг хэмжих 10 коэффициент
- 1.2 Хүний оюун ухааны чадвар болох EQ чадварын тухай
- 1.3 EQ чадвар чадварыг хэрхэн сайжруулах вэ?

ХОЁР ДУГААР БҮЛЭГ: ОНЛАЙН СУРГАЛТЫН ТУРШИЛТ СУДАЛГАА

- 2.1 Говьсүмбэр аймгийн төрийн албан хаагчдын судалгаа
- 2.2 Онлайн сургалтын туршилт судалгаа
- 2.3 Онлайн сургалтын төсөл

Дүгнэлт

Хавсралт

Ном зүй

Түгшүүр үг

Хүний оюун ухааны чадвар
Төрийн албан хаагч
Онлайн сургалт
Бие даан хөгжих

Судалгааны үндэслэл:

“Замат сайтай голд загас олон, зан сайтай айлд хүн олон цуглардаг.”
Өнөөгийн нийгэмд оюуны мэдлэг чадвараас гадна бусадтай харицах зан харицаа, хандлага сайтай нь амжилтад хүрдэг болсон байна. Аливаа албан байгууллагын амжилтад олон хүчин зүйлс нөлөөлдөгөөс ажиглан, албан хаагчдын харицаа хандлага, хамтын үйл ажиллагаа нь чухал үүрэтэй билээ. Тэвэл энэхүү харицаа хандлагыг нэмэгдүүлэхийн тулд хувь хүний хөгжлийн үр чадваруудыг зайлшгүй хөгжүүлэх шаардлагатай байна.

Орчин үед хүмүүсийн чадварыг тогтоохдоо IQ /Intelligence Quotient/ чадвараар биш EQ /Emotional Quotient/ чадвараар хэмждэг болсон байна. Эрдэмтэд “Өөрийн мэдрэмж сэтгэл санаагаа чадварлагаар удирдан, өөртөө буюу бусдад ашигтайгаар ашиглах явдал нь EQ буюу хүний сэтгэл хөдлөл, харицааны чадварын итгэлцүүрийг илэрхийлдэг” гэж үзжээ.

Мөн BBC агентлагийн мэдээлснээр “Хүний нөөцийн мэргэжилтнүүдийн 99 хувь, менежерүүдийн 95 хувь, ажилтнуудын 99 хувь нь EQ өндөртэй хүн ажилтан шалгаруулахад маш чухал үзүүлэлт болно” гэж хариулсан байна. Учир нь үүнийгээ хөгжүүлсэн хүмүүс өөрийгөө зөв илэрхийлж стресс өртөхгүй байхаас гадна ажлын амжилтын амни чухал үзүүлэлт болох багаар ажиглах чадвар өндөртэй байдаг нь аль хэдийн нотлогджээ.

Судалгааны ажлын зорилго:

- Төрийн албан хаагчдын EQ чадварыг технологийн дэвшлийг ашиглан сайжруулах арга судлан туршилтаар нотолж, цаашид хэрэгжүүлэх арга замыг боловсронгуй болгох

Судалгааны зорилтууд:

- Хүний оюуны чадварын судалгааны онолын арга зүйг судлах
- Төрийн албан хаагчдын оюун ухааны чадварын хэрэгцээ шаардлагын судалгаа
- Цаашид хэрэгжүүлэх арга замыг судлан төсөл боловсруулах

Судалгааны арга зүй

Мэдээлэл түүвэрлэх, эх сурвалжийн анализийн аргыг сэдвийн судлагдсан байдлыг тогтоож онолын хэсгийг боловсруулахад, ярилцлагын аргыг бусад төрийн албан хаагчидтай ярилцаж хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шинэ санаа гаргахад, индукцын судалгааны аргыг туршилтын явцад суралцагчийн хөгжилд гарч буй өөрчлөлтийг баримтжуулж, нотолгоожуулахад, статистик боловсруулалтын аргыг цуглуулсан мэдээлэлд боловсруулалт хийхэд тус тус хэрэглэв.

НЭГ ДҮГЭЭР БҮЛЭГ: ОНОЛЫН АРГА ЗҮЙ

1.1 Хүний оюун ухааныг хэмжих 10 коэффициент

1. IQ-INTELLIGENCE QUOTIENT. Танин мэдэхүйн оюун ухааныг хэмжих суурь ойлголт IQ нь тунгаан бодох, асуудлыг шийдвэрлэх, шинэ материал судлах чадварыг илэрхийлнэ. Өндөр хөгжилтэй орнуудын алдартай корпорацуд ажилтан авахдаа IQ-г нь шалгаж авдаг. Тухайлбал: Дэлхийн програм хангамжийн салбарт тэргүүлж буй Microsoft корпораци 120-с дээш IQ-тай програмистыг ажиглаж авдаг байна. АНУ тэргүүтэй өндөр хөгжсөн орны нэр хүндтэй их сургуулиудад элсэх үндсэн нөхцөл нь оюуны чадварын ерөнхий төстийн (SAT, GRE) босго оноог давах буюу IQ-ын өндөр байх явдал юм. Эрдэмтдийн судалгааны үр дүнд хүн төрөлхтний 0,4% нь 140-өөс дээш IQ-тай буюу сод ухаантай, 0,4% нь 70-аас доош IQ-тай буюу оюун ухааны хомсдолтой бөгөөд бусад 99,2% нь оюуны чадварын хувьд ерөнхийдөө ижил байдгийг тогтоожээ.
2. EQ-EMOTIONAL QUOTIENT нь сэтгэл хөдлөл, харилцааны чадварын илтгэлүүр. Зах зээлийн нийгэм нь хүний бүх талын хөгжил, ялангуяа харилцах урлагыг ихээхэн үнэлдгийг бид мэдэрч эхэлж байна. Нийгмийн харилцааны оюун ухаан гэгддэг EQ нь өөрийн болон бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох, сэтгэл хөдлөлөө зохицох илэрхийлэх, өөрийгөө урамшуулах, тэвчээртэй байх, үргэлж сэтгэл өөдрөг явах зэрэг цогц чадварыг харуулдаг. EQ өндөртэй хүн өөрийнхөө сэтгэлийн дотоод хөдлөлд автахгүй биеэ барих чадвар эзэмшсэн байх бөгөөд орчинтөйгөө зохицон, ажлаа амжилттай явуулж байдаг.
3. AQ-ADVERSITY QUOTIENT. Бэрхшээлийг даван туулах шаргуу зүтгэл, өөдрөг санаа, зориг эрмэлзлийг харуулдаг илтгэлүүр-AQ. AQ мутай хүн аливаа гэнэтийн явдалд амархан цочирдож, сэтгэлийн хөдөлгөөнд автаг бол өндөр AQ-тай хүн ямар ч хүнд нөхцлийг сэтгэлийн хатаар давж лидер болдог. Харвардын их сургууль бизнесийн ангийн оюутныхаа AQ-г хөгжүүлэхэд маш их анхаардаг.
4. CQ-CREATIVE QUOTIENT. Бүтээлч чадварын илтгэлүүр нь өөрийн бүтээх чадвараа зөв танин мэдэж, шинийг сэтгэл бодож, бүтээх чадвараа байнга дээшлүүлэх чадварыг харуулдаг. Зохион бүтээгчид, шинийг эрэлхийлэгчид бүтд л багаасаа CQ өндөртэй байжээ. Хүний хамгийн их бүтээлч сэтгэлгээтэй үе бол хүүхэд нас. Иймд та хүүхдийнхээ бүтээлч сэтгэлгээг байнга урамшуулж, хөгүүлэн дэмжиж хөгжүүлж байх ёстой.
5. SQ-SPIRITUAL QUOTIENT буюу оюун санааны хүч чадлын илтгэлүүр нь биеэ дайчилж зорьсондоо хүрэх сэтгэлийн зориг тэвчээрийг харуулдаг. SQ нь өөрийн мэдлэг туршлагаа мөргөн ухаан, азтай алшин болгон хувиргах сэтгэхүйн чадвар юм.
6. DQ-DEVELOPMENT QUOTIENT. Өөрийн бие бялдрын байдал онцлогийг тодорхой мэдэж, алхам алхмаар биеэ хөгжүүлэн зорьсон зорилгодоо хүрч амжилт гаргах чадварын илтгэлүүр. DQ өндөртэй хүн өөрийн биеийн онцлог ба чадварыг

зөв үнэлж, тогтвортой, системтэй хичээллэх чадвартай болдог. Ялангуяа урлаг, спортын амжилт ДQ-гээр дамжин илэрдэг. Хүний нийгэмд өөрийгөө зохицуулж, үйлчийнхээ хэм хэмжээг тогтоох чадвар. MQ өндөртэй хүн сайн мууг ялгах, бусдыг чин сэтгэлээсээ хайрлах 8. NQ-NET QUOTIENT. Мэдээллийн сүлжээнд ажиллах чадварыг илэрхийлнэ. NQ бол орчин үед модонд орж байгаа нар томьёо бөгөөд залуу үеийг боловсруулах практик модель. NQ нь мэдээлэлтэй харьцах чадвар болон мэдээллийн орчинд өөрийгөө захирах чадварыг хүүхдэд эзэмшүүлдэг. 9. BQ-BONDING QUOTIENT. Эцэг эх үр хүүхдийн дотно харилцааны үзүүлэлт. Ялангуяа 0-7 насны хүүхдэд эцэг эхчүүд BQ өндөртэй байх хэрэгтэй. BQ өндөртэй эцэг эхчүүд өөрийн үр хүүхдэд онцгой халамж тавьдаг, хүүхдийнхээ онцлогийг мэдэх чадварыг эзэмшсэн байдаг. BQ өндөртэй хүүхэд өөртөө итгэлтэй сэтгэл хангалуун байх бөгөөд эцэг эхдээ улам дотноссоноор EQ нь өснө, хүүхдийн сэтгэл санаа тайван болж гадаад ертөнцийг сонирхсоноор IQ өснө, гар бүлийн уур амьсгал халуун дулаан болсноор MQ өснө. 10. FQ-FINANCIAL QUOTIENT. Хөрөнгө мөнгийг оновчтой захирах чадварыг илтгэх илтгэлүүр. Өндөр хөгжилтэй орны иргэд хүүхдийнхээ FQ-г дээшлүүлэхийн тулд ирээдүйн саятнуудын клубт хичээллүүлж, Монопол (саятан) зэрэг тоглоомуудыг багаас тоглуулдаг байна. EMOTIONAL INTELLIGENCE ГЭЖ ЮУ ВЭ? — АМЖИЛТАД ХҮРЭХЭД IQ ХАНГАЛТҮЙ ГЭНЭЭ

1.2 Хүний оюун ухааны чадвар болох EQ чадварын тухай

Харвард Бизнес Шүүмж дэх сонинч давуу талын тухай нийтлэлд EQ emotional intelligence ч мөн амьдралын эздэрээ, яриалтай нөхцөл байдалд давуу тал болдог тухай хөндсөн билээ. Энэ удаа EQ гэж юу болох, түүнийгээ хэрхэн сайжруулж болох тухай мэдээлэл хүргэе. Хүний нийгэмд амьдарч буйгаас хойш хүний амьсгал мэдрэх, түүнд хариу үйлдэл үзүүлэх чадвар хувь, хувьсгалын аль ч талбарт нэн чухлыг хан хүнлүй хүлээн зөвшөөрнө. EQ нь яг ийм чадварыг тодорхой бүрдүүлдэг цэгтэй задлан илэрхийлж индексжүүлсэн ойлголт. IQ буюу оюуны чадамжгийн коэффициентийг бүгд мэддэг, гэхдээ амьдрал дээр заримдаа EQ нь IQ-ээс ч илүү амжилтад хүрч, сайхан амьдрахад тусалдаг гэдгэнэ. IQ амжилтын 10 хувийг л шингидэг гэх дүн гаргасан судалгаа ч байдаг. Ерөнхийдөө дундаж IQ-тай хүмүүс асар өндөр IQ-тнуудаас 70 хувь илүү амжилттай байдаг сонин онцосгогч EQ хэмээх ойлголт гарч ирснээр илүү тодорхой хэмжүүрээр тайлж өгчээ. Анх энэ ойлголтын талаар нөлөө бүхий нийтлэл гаргаж олны ойлголтыг гүнзгийрүүлсэн Ж.Майер нар Амьсгал ойлгох, хүлээж авах — Амьсгал эргэлүүлэл, асуудал шийдвэрлэхэд ашиглах — Амьсгалын учир шалтгааныг, утгыг ойлгох — Амьсгал удирдах гэсэн дөрвөн талаас тайлж гаргасан байдаг. IQ муутай ахмад хүн байж

болно, харин EQ муутай насанд хүрсэн хүн гэж байхгүй. Өөрөөр хэлбэл таны EQ доогуур байвал та харахад хөгширсөн ч “хазахад” хүүхэд хэвээр байна гэсэн үг.

1995 онд Харвардын их сургуулийн профессор Даниел Голмэн (Daniel Goleman) "Emotional Intelligence" бүтээлдээ EQ хэмээх чухал ойлголтыг гаргаж ирсэн. Түүний тодорхойлсноор EQ гэдэг нь "Өөрийнхөө болон бусдын ашигтай үйл ажиллагааг бие махбодиор биш сэтгэлтэй нь харьцан зохицуулах, удирдах мөн хүмүүсийг идэвхжүүлдэг, тэднийг чин сэтгэлээсээ ойлгодог чадвар юм" гэжээ.²

Голмэний бичсэн ном хожим онол болтлоо хөгжиж дэлхийн өнцөг булан бүрт үр ашгаа өгсөөр байна. Голмэн EQ-г хөгжүүлэх 5 алхмыг тодорхойлжээ.



²<http://www.setgel.org/2014/08/emotional-intelligence-eq.html>

1.3EQ чадвар чадварыг хэрхэн сайжруулах вэ?

1. *Өөрцгөө мэдэхүй*: Өөрийгөө танин мэдэх, өөрийнхөө сэтгэл хөдлөл, мэдрэмжээ олж авах, ойлгох.
Өөрийн сэтгэл хөдлөлөө зөв ойлгож танихын тулд өөрийнхөө жинхэнэ дотоод мэдрэмжийг сонсож чаддаг, өөрөөр хэлбэл өөрийгөө мэддэг байна гэсэн үг. Өөрийгөө мэдэхүй нь өөртөө итгэлтэй байдалтай салшгүй холбоотой.
 2. *Өөрцгөө хянах*: Сэтгэл хөдлөлөө удирдан зохицуулж сурах
Ихэнх хүн ямар нэг эмц төрөхөд удирдлагыг гартаа авахаас илүү эмочод удирдлагаа алддаг. Үүр, бүхимдэл, дээресс гэх мэт сөрөг эмочыг сарниах аргаа олсон, шударга, дотоод бие хүн нь нэгдмэл чанартай, хийсэн зүйлдээ хариуцлага үүрч чаддаг, өөрчлөлтөд уян хатан хариу үзүүлдэг, шинэ зүйлст нээлттэй хүмүүс өөрийгөө илүү хянаж, удирдаж чаддаг.
 3. *Мотиваци*: Өөртөө урам зориг өгөх, сэтгэлээрээ байнга эрч хүчтэй байх
Ямар нэг зорилгын төлөө мотивациаа хадгалж чадах эсэх нь зорьсон зүйл чинь тодорхой эсэх, эерэг хандлагатай эсэхээс ихээхэн хамаарна. Дасгалжих замаар илүү эерэг хандлагатай болж болдог. Мотивацитай байхад мөн хамгийн сайн түвшинг үргэлж зорих, байгууллага хамт олны зорилгод ухамсраараа зөвшиж итгэл үнэмшилтэй байх батана.
 4. *Бусдыг мэдэхүй*: Хүмүүст ямар саналдаж байгааг, тэдний сэтгэлийг ойлгох, ухаарах
Нийм чадвартай хүмүүс эргэн тойрныхондоо үйлчлэх, бусдыг хөгжүүлэх, олон төрлийн хүмүүстэй харицгаа өргөжүүлэх, хамт олны эмочыг уншиж улстөрийн бэлэнсэлт мэдэх тал дээр илүү чадвартай байдаг.
 5. *Бусад нөлөөлөх*: Хүмүүсийн сэтгэл санааг зохицуулж, удирдаж чаддаг байх.
Бусадтай харицгаа хүн хоорондын харицгааны чадвар та болон таны амьдралд туйлын чухал үүрэг гүйцэтгэх болно. Мэдлэг мэдээлэл хүн бүхний гарт холбогдсон өнөө цагт хүнийг ойлгож, хүнтэй ярицаж, хүнтэй хэлэлцэх чадвар хэзээ хэзээнээс илүү чухал болж ирлээ. Хамгийн чухал нийгмийн харицгааны уя чадварт: нөлөөлөх ятах чадвар, манлайлах, тэндийг өөрчлөх, зөрчлийг шийдвэрлэх, ойр дотно харицгаа үүсгэх, хамтрах, багаар ажиглах чадвар орно.
- Энэхүү 5 алхмыг өөртөө хэрэгжүүлж дадаснаар EQ-ийн чадвараа сайжруулах боломжтой.

Таны EQ хэр сайн бэ?

Тест өгөлгүйгээр жирийн амьдралд өөрийгөө ийм таван үзүүлэлтээр шинжээд сул давуу талаа мэдэх авах тийм амаргүй. Гэхдээ дараах шинжүүдээс танд байвал сайны дохио:

- Та мэдрэмжээ маш баялаг, янз бүрийн үгээр илэрхийлдэг. Эмоцоо сайн таньдаггүй хүмүүс нэг л тиймхэн байна гээд зогсох бол өөрийгөө сайн мэдэрдэг нь цухалдаад, бухимдаад, гунигийн, тэсвэр алдсан гэх мэт олон өнгөөр илэрхийлнэ.
- Та бусдын талаар, бусдыг юу мэдэрч байгаад сониуч байна
- Та өөрийнхөө юунд мундагийг, юунд базаахгүйгээ сайн мэддэг
- Та бусдын характерыг оновчтой ялгаж харж, үнэлж чаддаг
- Таныг хүмүүс тийм амар доромжилж чаддаггүй
- Та Үгүй гэж хэлж чаддаг
- Та алдааны араас удаан гутардаггүй
- Та ямар нэг юм эргэж хариу горьдолгүйгээр өгч чаддаг
- Та дургүйцэх, үзэн ядах мэдрэмжийг удаан тээдэггүй
- Та заавал бүхнийг төгс байлгах гэж зүтгэдэггүй
- Та сөрөг хандлагатай, хар хортой хүмүүсийг тайвшруулж нейтраль болгож чаддаг
- Та заримдаа бүхнээс өөрийгөө тусгаарлаад амарч чадна
- Та байгаа зүйлдээ талархаж чадна
- Та сайн унтаж амардаг
- Та бусдын сэтгэгдлээс үл хамааран аливааг таашааж, сэтгэл хангалуун байж чадна

EQ-ийн чадамжаараа ялгаатай хүмүүсийн нийтлэг шинжүүдийг харьцуулбал:



Дээрх хүснэгтээс дүгнэлт хийхэд IQ өндөртэй хүмүүсээс илүү EQ өндөр хөгжсөн хүмүүс нийгмийн бүх салбарт аливаа асуудлыг эерэгээр харж, ханддаг нь харагдаж байна.

EQ нь хэр хурдтай сэтгэж сэргэлэнтэж байгааг биш, юманд сэтгэлээсээ хандах хандлагыг илрүүлдэг. Өөрийн мэдрэмж сэтгэл санаагаа удирдан зөвөөр ашиглах төдийгүй бусад хүмүүсийн мэдрэмж сэтгэл санааг мэдрэн анхаарах чадвар хөгжсөн хүмүүс амжилтад хүрдэг.

Аливаа хүн EQ чадвараа хөгжүүлснээр янз бүрийн асуудал гарахад бусдаас туслалцаа авалгүй, өөрөө сэтгэлээр уналгүй хөнгөхөн зохицуулдаг, бусдын сэтгэл санаа хандлагыг мэдэрч ойлгодог, хэрхэн харилцах, яаж арга эвийг нь олохоо сайн мэддэг, нийгмийн харилцааны ур чадвар өндөртэй болдог.

ХОЁР ДУГААР БҮЛЭГ: ОНЛАЙН СУРГАЛТЫН ТҮРШИЛТ СУДАЛГАА

2.1 Говьсүмбэр аймгийн төрийн албан хаагчдын судалгаа

Говьсүмбэр аймгийн төрийн статистик тоог доорх хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 3. Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ, хариуцлагын хэлбэрээр, 2018 он

Аймаг	Хариуцлагын хэлбэр	үзүүлэлт
Говьсүмбэр	Компани	236
	Хоршоо	18
	Нөхөрлөл	14
	ТӨҮГ, ОНӨҮГ	6
	Төсвийн байгууллага	54
	Төрийн бус байгууллага	51
	Бусад	2
	Бүгд	381

/Эх сурвалж-Говьсүмбэр аймгийн аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын танилцуулга-2018 /

Үүнээс дээрх харилцаа хандлага болон бусад чадварыг сайжруулах онлайн сургалтын хэрэгцээ шаардлага байгааг доорх тооноос харж болох юм. Үүнд:



Төрийн албаны 8 байгууллагын 170 гаруй албан хаагчид сургалтын хэрэгцээ шаардлага байна гэдгийг асуулгын үр дүнгээс харж болно.

№	Байгууллагын нэр	Оролцогчдын тоо
1	Говьсүмбэр аймаг дахь Уул уурхайн жишиг сургууль Политехник коллеж	73
2	АЗДТГ Нийгмийн бодлогын хэлтэс	8
3	Улсын бүртгэлийн хэлтэс	14
4	Сүмбэр сумын ЗДТГазар	30
5	Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газар	7
6	Хөдөлмөр хамламж үйлчилгээний газар	15
7	Нийгмийн даатгалын хэлтэс	12
8	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	14

2.2 Онлайн сургалтын туршилт судалгаа

Тус онлайн сургалтыг 2016-2017, 2017-2018 оны хичээлийн жилүүдэд өөрийн сургуулийн насанд хүрэгчдийн сургалтаар туршиж, амжилттай төрсөн билээ.

2016-2017 оны хичээлийн жилд Уул уурхайн нярав, хангамж мэргэжлээр нийт суралцагчийг "Онлайн сургалт"-аар онолыг мэдлэгийг өгч, хугацаатай даалгавар өгөн бие даан судлуулан амжилттай төрсөн. Даалгаварыг тухайн цаг хугацаанд нь онлайнгаар авч шалган багш нар "Чадамжтай" гэсэн үнэлгээг өгч, мэргэжлийн үнэмлэхийг гардуулж өгсөн байгаа.




- 2017-2018 оны хичээлийн жилд Налайхын 353-р цэргийн ангийн ХММАУ,3Техникчийн ангид мөн онлайнаар сургалтыг амжилттай явуулж 2018-2019 онд төгсөлтөө хийсэн байгаа.



№	нэрс	Х1/28			Х1/29			Х1/30		
ХАБ-ЫН ТЕХНИКЧ										
1	Б.ЗОЛЗАЯА				Т			Т		
2	Б.МУХАМЕД				Т			Т		
3	Х.БАТ-ӨЛЗИЙ				Т					
4	Д.БАТ-ОТГОН				Т			Т		
5	Н.ЭНХ-ЕРТӨНЦ				И			И		
6	К.АМГАЛАНЖАМЦ	судалсан						И		
7	Ю.ДУГАРМАА	И			И			И		
ХММАУ-ЫН ТЕХНИКЧ										
8	Ч.НЭРГҮЙ	судалсан				И			И	
9	Е.АСЫЛБЕК	И				И			И	
10	Д.ЦОГТ									
11	Р.ЦОГТОО	судалсан							И	
12	М.БАТДОРЖ	судалсан							И	
13	Д.ЭНХТӨР				Т					
14	Б.ГАНБОЛД				Т					
15	Д.ЭНХБАЯСГАХ				Ө			Ө		
16	Н.НЯМДОРЖ				Т					
17	Д.БАТСҮХ				Т					
18	Б.АЛТАНШАГАЙ				Т					
19	Ц.ЭЛБЭГ-ОЧИР	И			И				И	
20	Ц.БАТСАЙХАН	И			И				И	
21	Б.НЯМБАЯР	И			И				И	
22	Д.ГАНСАНЧИР				И				И	
23	Д.МӨНХМАНДАХ				Т				И	

Налайхын цэргийн ангийн ирцийн бүртгэл болон онлайнаар суралцсан ахлагч,
офицерууд

"Онлайн сургалт"-аар амжилттай төгссөн суралцагчдын тоо




Туршилт судалгааны дүгнэлт

Дээрх 2 сургалтаар нийт 26 хүн 100% төгссөн нь туршилтаар харагдаж байгаа бөгөөд энэхүүн онлайн сургалтыг амжилттай явагддаг болохыг нотлон харуулж байна.

2.3 “Онлайн сургалт”- ын төсөл


Энэхүү онлайн сургалт нь туршилт судалгаагаар амжилттай хэрэгжиж байгаа нь нотлогдсон учир Төрийн албан хаагчдын EQ чадварыг хөгжүүлэх тухайн сургалтыг явуулах “ШАТАЛСАН ОНЛАЙН СУРГАЛТ”-ын төслийг танилцуулж байна.

Сургалтыг ГСА-ийн төрийн 8 байгууллагад туршилтаар эхлүүлэн цаашид түгээн дэлгэрүүлж, хувь хүний хөгжлийн чадваруудыг нэмэгдүүлэх зорилго тавин ажиллаж байна. Төслийг Хавсралтаар харууллаа.



Дүгнэлт

EQ нь хамгийн эхлээд өөрийгөө сайн ойлгохоос эхэлнэ. Дараа нь бусдыг сайн ойлгож, бусдад өөрийгөө таниулах, бусдыг чин сэтгэлээсээ хайрлах, туслах, итгэх, халамжлах, өглөө ажилдаа ирээд, бусадтайгаа зүгээр сайхан инээмсэглэн мэндлэх зэрэг нь EQ чадварын хамгийн анхан шатны илрэл юм. Гэхдээ эдгээр зүйлийг хийхэд ямар нэгэн албадлагаар биш, сэтгэлээсээ бүр таны зуршил болсон байх хэрэгтэй юм.



Цаг хугацаа, хөрөнгө мөнгө хэмнэсэн байдлаар ажлын байранд сурах нөхцөл боломжийг “Шаталсан онлайн сургалт”-аар өгч, төрийн албан хаагчдын EQ чадварыг хөгжүүлэх юм.

Ингэснээр төрийн албан хаагчид өөрийн хандалагаа өөрчилж, ажилд хандах сэтгэлгээгээ өөрчлөн өөрөө өөртөө урам өгөх, бусадтай зөв боловсон харьцах, ажлын сэтгэл ханамж нэмэгдэнэ.

Мөн төрийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, нийгэм дэх нэр хүнд өсөн, цаашид төрийн албан хаагчдын ёс зүй хариуцлага сайжирна.

Ном зүй

1. Отгонцэцэг Д. “Сурган хүмүүжүүлэх зүйн үндэс” . УБ., 2013
2. Дэлгэрсайхан Ц. Оюунгэрэл Ч. “Сургалтын шинэлэг аргуудаас суралцахуй”. УБ., 2004
3. “Сургалтын технологийн шинэчлэл” илтгэл, сургалтын материал. УБ., 1999
4. “Сургалтын аргазүй” илтгэл, сургалтын материал. УБ., 1999
5. Ичинхорлоо Ш. “Багшийн ном”. УБ., 2011
6. Энхжаргал Л. “Багшлахад суралцахуй”. УБ., 2008

Интернэтээс ашигласан веб сайтууд

1. <https://www.facebook.com/delhiin.zuuch/posts/1624319024452316>
2. <http://www.bolod.mn/mobile.php?nid=111720>
3. <http://www.setgel.org/2014/08/emotional-intelligence-eq.html>
4. <http://ganzorigulziibayar.blogspot.com/2015/05/iq-vs-eq-round-one-7.html>
5. https://en.wikipedia.org/wiki/Emotional_Intelligence

ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Овог нэр: Мандах овогтой Баярмаа

Сургууль: УУЖС Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж

Мэргэжил: Уул уурхайн менежмент

Албан тушаал: Эдийн засгийн багш

Ажилласан жил: 11

Боловсролын зэрэг: Бизнесийн удирдлагын магистр

Мэргэжлын зэрэг: Тэргүүлэх багш

Овог нэр: Бадрал овогтой Мэндбаяр

Сургууль: УУЖС Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж

Мэргэжил: Багш

Албан тушаал: Гидравликийн мэргэжлийн багш

Ажилласан жил: 19

Боловсролын зэрэг: Боловсрол судлалын магистр

Мэргэжлын зэрэг: Заах аргач багш